# Агуулга

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ ..... 2
ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ..... 3
ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ..... 4
БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛОН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛ НӨЛӨӨЛЛҮҮДИЙН ХУРААНГУЙ ..... 11
СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУРААНГУЙ ..... 12
СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 16
НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 19
ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 20
ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ ..... 22
НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ..... 24
ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 25
ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 26
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР ..... 29
ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 34
ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ ..... 35
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ ..... 37

# БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

"Демситрейд" ХХК нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29- ний өдрийн А/618 тоот тушаалаар шинчлэн баталсан иргэн, аж ахуй нэгж байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх "Байгаль орчны менежментийн төлөвлгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын дагуу Цагаан чулуутын ам алтны шороон ордын 2024оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлгөө гэж байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.8-д заасан төлөвлөгөөг ойлгоно. Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагын хянан баталсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг нь төслийн үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэхийн зөвшөөрсөн байгаль орчны үндсэг баримт бичиг болно.

Цагаан чулуутын амны алтны шороон ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлгөөний байгаль хамгаалах төлөвлгөөнд байгалийн нөөц баялгийг ашиглах явцад байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлийн өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгалаа.

Цагаан чулуутын амны алтны шороон ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байгаль орчны төлөв байдлын өөрчлөлт, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх, сөрөг нөлөөллийн эрчим, цар хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхигй тогтоох ажиглалт, хэмжилт, дээжлэлт хийх байршил, давтамж, хариуцах этгээд, шинжилгээний арга, шаардагдах зардыг тооцож тусгалаа.

"Демситрейд" ХХК нь 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлгөөг байгаль хамгаалах хууль тогтоомж, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүн, батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлгөө (5 жил)-нд үндэслэн, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлалын 4 дүгээр хэсгийг баримтлан боловсруулав.

# ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## Төслийн ерөнхий мэдээлэл

**Төсөл хэрэгжүүлэгч:** "Десмитрейд" ХХК

**Регистерийн дугаар : 2711184**

**Улсын бүртгэлийн дугаар: 2711001052**

**Төслийн нэр:** MV-020834 дугаартай "Сайр уул" нэртэй талбайн Цагаан чулуутын ам алтны шороон орд

**Захирал: Б. Мягмаржав**

**Утас: 88053300**

**Төслийн байршил:** "Сайр уул" нэртэй MV-020834 дугаартай тусгай зөвшөөрлийн талбай нь Сэлэнгэ аймгийн Мандал, Баянгол сумдын нутагт, Улаанбаатар хотоос баруун хойш 135 км, Баянгол сумаас зүүн тийш 20 км-т байрлана. байр зүйн зургийн L-46-81 дугаартай хавтгайд байрлана.




Зураг 1.Төслийн талбайн байршил

## Тусгай зөвшөөрөл эзэмшигч

Сэлэнгэ аймгийн Баянгол, Мандал сумын нутагт орших "Сайр уул" нэртэй 3575.84 га талбай бүхий ашигт малтмалын MV-20834 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2017 оны 05-р

сарын 31-ны өдрийн АМГТГ-аас “Демситрейд” ХХК-нд олгосон байна.

Ашиглалтын хугацаанд уурхайгаас нийтдээ 3942.9 мян.м$^3$ хөрс, 170.6 мян.м$^3$ элс олборлоно. Хөрс хуулалтын дундаж коэффициент 23.1 м$^3$/м$^3$ байна. Үйлдвэрлэлийн нөөцийг бодоход 3% буюу 4.48 мян.м$^3$ элс ашиглалтын явцад хаягдаж, элсний давхаргын доод хэсэг, борт, таазнаас 14.98% буюу 25.57 мян.м$^3$ хөрс нэмэгдэж нийт олборлох үйлдвэрлэлийн нөөц 170.6 мян.м$^3$ болж байна. Ордын хөрсний зузаан зарим хэсэгтээ их 9.8-45.0 м байгаа ба уурхайн гүн дунджаар 23.0 м байхаар байна. Жилд 160 хоног ажиллана. Техник-эдийн засгийн үндэслэлд газрын гадаргаас доош хамгийн ихдээ 45.0 м хүртэл байхаар тооцсон бөгөөд 9С блокын дундаж гүн 12.3 м, 8В блокын дундаж гүн 11.6м байна. Ил уурхайгаас олборлосон алт агуулагч элсийг угааж ангилан 20 мм-ээс доошиx ангилалын элсийг нам дүүргэлтийн шлюз, нам дүүргэлтийн шлюзийн баяжмалыг сэгсрэх ширээгээр нийт 88.0 %-ийн металл авалттайгаар баяжуулж 931 сорьцтой 85.59 кг шлихийн алт, 79.0 кг химийн цэвэр алт гаргана. Орд ашиглалтын хугацаанд баяжуулах технологиос 107630 м$^3$ эфелийн хаягдал мөн 54160 м$^3$ галийн хаягдал гарна.

## ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Уул зүй: Тусгай зөвшөөрлийн талбай нь Сэлэнгэ аймгийн Баянгол, Мандал сумдын нутаг дэвсгэр дээр оршдог. Сэлэнгэ аймаг нь Монгол улсын хойд хэсэгт Орхон Сэлэнгийн савын дунд зэргийн уулс бүхий нутгийг эзлэн оршино. Аймгийн нутгийн баруун хойд хэсгээр Юрийн хурдас, өмнөд хэсгээр нь герциний боржин, зүүн хэсэгт нь гүний боржин тархжээ. Аймгийн нутагт нүүрс (Улаантолгой, Шарын гол), төмөр (Төмөртэй, Төмөртолгой), алт (Их Алтат, Бугант, Бороо, Заамар, Ноён уул, Толгойт) болон барилгын материалын баялаг бий. Монгол орны газар зүйн мужлалын хувьд тус орд нь Хэнтийн хөдөлгөөнт бүсийн Монгол-Агнуурын тэнгисийн герциний геосинклиналийн мужид хамрагдах бөгөөд эх газрын эрс тэс шинжтэй.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан

Уур амьсгал: Сэлэнгэ аймгийн Мандал, Баянгол сумдын нутаг нь Монгол орны ойт хээрийн бүсэд орших ба манай орны тариалангийн гол бүс нутаг юм. Судалгааны бүс нутаг нь Монгол орны бусад нутгийн нэгэн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай боловч чийг, дулааны нөхцөлөөрөө дунд зэргийн буюу дулаавтар, хуурай нөхцөлтэй бичил мужид хамрагдана.

Сүүлийн 5 жилийн агаарын температурт онц өөрчлөлт ороогүй байгаа боловч хүйтэн өвөлтэй жил илүү халуун зун болдог мэт ажиглагдаж байна. 3 станцын мэдээг харьцуулж харахад Сэлэнгэ аймгийн Мандал сум нь хамгийн хүйтэн өвөл хамгийн халуун зун болж байхад Төв аймгийн Борнуурт харьцангүй сэрүүн зун дулаан өвөл болдог нь ажиглагдаж байна. Харин

Бороогийн станын агаарын температурын мэдээ нөгөө 2 станцийнхтай харьцуулахад дундаж утгыг зааж байна. Төсөл хэрэгжих талбай орчинд жилдээ 290-305 мм хур тунадас унадаг. Энэ нь өндөр уулсын нутгаас бага боловч говь цөлөөс бол бүр их байна. Дулааны улиралд хур тунадасны 92% буюу 282 мм орно. Дулааны 4-10 сард бороо, үлдсэн 15% орчим нь хүйтэн улирлын 11-3 саруудад цас хэлбэрээр орно. Хур тунадас жилээс жилд хэлбэлзэл, өөрчлөлт ихтэй байдаг. Салхины дундаж хурд 4-8 м/сек, голдуу баруун хойд, хойд, зүүн хойд зүгээс салхилах бөгөөд заримдаа 20-22 м/сек хүрдэг.

Агаарын чанар: Тухайн орчинд байгалийн болон антропологийн гаралтай агаарын бохирдлын ямар нэг илрэл байхгүй бөгөөд цаашид энэхүү цэнгэг агаартай орчны унаган төрхийг хадгалан өөрсдийн эрхлэх уул уурхайн үйл ажиллагаандаа дэвшилтэт арга технологи ашиглах нь зүйтэй.

Хөрсөн бүрхэвч: Цагаан чулуутын ам алтны шороон орд Монгол орны хөрс-газарзүйн мужлалын хувьд Хангайн их муж Хэнтий муж, Хэнтийн захын 39-р тойрогт хамаарагдаж байна. Цагаан чулуутын ам алтны шороон орд орчим Хархүрэн хөрс, Сайргархаг нимгэн Хархүрэн хөрс, Нугархаг Хархүрэн зэрэг хөрснүүд тархсан байна. Хөрсний урвалын орчин (pH) ерөнхийдөө сул шүлтлэгээс - шүлтлэг (7.25-8.36), Ялзмагын агууламж үржил шимт үе давхаргадаа өндөр 2.09-3.73%, доод үе давхаргуудад харьцангуй бага 0.14- 0.67%, Нугархаг Хархүрэн хөрсөнд карбонат байхгүй. Нимгэн Хархүрэн хөрс 12 см-ээс доош маш их карбонатын хуримтлалтай (20.36%), Хөрсний электрон кондактив 0.089-0.335 dS/m3 байгаа нь давсжилтгүй гэж үзэж болно. Хөдөлгөөнт фосфор, кали хэвийн байна. Хөрсний хими шинж чанраас харахад ургамал ургахад тохиромжтой, үржил шим сайтай хөрс байна. Хөрсний ус-физик шинж чанарыг харахад бүх хөрс элсэнцэр, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, харин Хархүрэн хөрсний 50-80 см гүнд элсэрхэг шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Ерөнхийдөө нягтавтар шинжтэй, Сайргархаг нимгэн Хархүрэн хөрс чулууны агууламж өндөртэй, бусад хөрсний тархалтанд чулуу маш бага байна. Цагаан чулуутын ам алтны шороон орд орчим хөрсөн бүрхэвчийн эвдрэл байхгүй

Гадаргын ус: Ýнэхүү алтны уурхай нь Õараа голын ñаâ газар Бороо голын баруун эрэг дээр Зуун модны гол Бороо голын уулзâараañ дээш 1.5км-т байрлана.

Хэнтий нурууны салбар уулсаас эх авсан Шаварт, Шивэрт голууд Борнуур сумаañ дээш 4 км-т нийлж Бороо голыг үүсгэнэ. Хоёр боомтын хооронд Бороо гол сумын т$^{o}$вийн зүүн талаар Шар хоолой, Борнуурын орчмоос гарах Сүжигт булгийн гол цутгадаг. Голын уñ хурах талбай 616 км2, голын урт 52 км, орд хүртэл уñ хурах талбай 400км2, голын урт 34км. Урсацын нормын зураг, урсац ба ус хурах талбайн дундаж өндрийн хамаарал болон манай оронд мөрдөгдөж

байгаа ажиглалт судалгаагүй жижиг голын урсацыг тооцдог аргачлал, эмпирик томъёог үндэслэн Бороо голын олон жилийн дундаж урсацыг тооцоход урсацын модуль (Мо) 15,5 л/с*км2, урсацын норм (Q) 24,6 м3/с, урсацын итгэлцүүр (Cv) 0,25, орд орчимоор тооцоход урсацын модуль (Мо) 6.56 л/с*км2, урсацын норм (Q) 16.4 м3/с, урсацын итгэлцүүр (Cv) 0,27 байна.

Зуун модны гол нь Бөмөг уул (1575.5м)-ын зүүн хойноос усжина. Голын урт 16 км, ус хурах талбай 60км2. Урсацын нормын зураг, урсац ба ус хурах талбайн дундаж өндрийн хамаарал болон манай оронд мөрдөгдөж байгаа ажиглалт судалгаагүй жижиг голын урсацыг тооцдог аргачлал, эмпирик томъёог үндэслэн Зуун модныы голын олон жилийн дундаж урсацыг тооцоход урсацын модуль (Мо) 15,5 л/с*км2, урсацын норм (Q) 24,6 м3/с, урсацын итгэлцүүр (Cv) 0,25, орд орчимоор тооцоход урсацын модуль (Мо)
6.56 л/с*км2, урсацын норм (Q) 16.4 м3/с, урсацын итгэлцүүр (Cv) 0,27 байна.

Хараа гол Õэнтий нурууны баруун урд хажуугийн ñалбар уулñааñ эх аâах Баянгол нь Õараа голын эх юм. Õараа голын уñ хурах талбай 14538 ам км, 310 км урт, дундаж уналт нэг километрт 4 метр ба голын °рг°н нь дээд хэсэгт (Мандал гол) 15-20 метр, дунд хэсэгтээ (Түхэл °рт°°ний хэсэгт) 20-30 м, адагтаа (Дархан хот) 30-45м өргөн байна. Óулñ хоорондын хөндий Баянбуурлааñ Түнхэл өнгөртөл нарийн хөндийгөөр урññаар Сэлэнгэ аймгийн Мандал ñумын нутгааñ эхлэн голын хөндий өргөñөн 5-10 км өргөн болох ба зарим хэñэгтээ 15 км хүрнэ. Ýнэ хэñэгт голын гольдролын тахирлал нэмэгдэж хэд хэдэн ñалаа татуурга үүсгэнэ. Х°ндийн хойд энгэрт Зүүн хараа, Баруун хараа хот маягийн үйлдвэржсэн суурингууд орших б°г°°д эдгээр нь хараагийн голын усны бохирдолтонд зонхилох н°л°° үзүүлнэ. Бороогийн цутгалаас цааш Хараа гол умард зүг алсуур тохойрч хойт зүг хандан хээр талын дундуур тахиралтан урсаж байгаад х.°. 49036’69”, д.у.105049’63”–ийн солбилцолд Орхон голд цутгана. Голын гольдролын ёроол ихэâ÷лэн хайрга, элñ, зарим газраа лаг шороо байх ба харьцангүй бат бэх, уñны ургамал бараг байдаггүй. Хараа голын ихэнх цутгал нь голынхоо зүүн талаас буюу урсгалын чигийн баруун гараас цутгана. Үүний дотроос томоохон цутгалд тооцогдох нь Баян, С°гн°г°р, Түнхэл зэрэг услаг голууд юм. Хараа гол нь хэдийгээр Туул, Ер°° гол шиг °нд°р уулсаас эх аваагүй боловч түүний цутгал болох дээрхи голууд нь Бага Хэнтийн нурууны хатгийн °нд°р уулсаас усжиж Хараа голд цутгадаг. Урсацын норм. Хараа голын урсацын горимын үзүүлэлтүүдийг Сэлэнгэ аймгийн Мандал сумын тооцооны х°ндлүүрт тодорхойлохдоо ус судлалын Хараа-Баруунхараа харуулын 1952-2003 оны ажиглалтын мэдээг үндэс болгов. Ус судлалын Хараа-Баруунхараа харуулаар урсацын норм нь 11.7м3/с байна.

Газрын доорх ус: Бороогийн бүс нутагт орших Сайр уулын талбай орчимд байнгын шинжтэй хөрсний ус тархаагүй байна. Хөрс нь агаарын хур тунадсаар тэжээл авч капиляр байдлаар ургамал, ялзмагийн тэжээлийн нэг хэсэг болдог. Харин гидрогеологийн үүднээс авч үзвэл Сайр уулын амны алтны ордын район нь:

1. Газар доорхи усны нөөцгүй буюу үндсэндээ хуурай, дээд Кембри- доод Ордовикийн настай Харагийн грүпийн тунамал- хувирмал элсжин, алевролит, занар зэрэг үндсэн чулуулаг,
2. Газар доорхи усны хязгаарлагдмал нөөц бүхий аллюви- пролювийн элс, шавар, элсэнцэр, шавранцараас бүрдсэн сэвсгэр хурдас гэсэн хоёр төрөлд хувааж болох бөгөөд экологийн хувьд үндсэн чулуулгийн өгөршил, тектоникийн ан цаваар, сэвсгэр хурдсын нүх сүвээр дамжин ус нэвчих боломжтой.

Сэвсгэр хурдсын нүх сүвээр дамжин оршдог газар доорхи ус нь бохирдолтод амархан өртөж болзошгүй эмзэг орчинд хамаарна.

Ургамлын нөмрөг: Судалгаа явуулсан нутаг нь ургамал газарзүйн мужлалаар Евро- Азийн хээрийн муж, Дагуур Монголын хээрийн хошуу, Баруун Хэнтийн уулын хээрийн тойрог, Хараа голын дүүрэгт хамааргдана. Хараа голын дүүрэгийн ургамал бүлгэмдлийн ихэнх нь тал хээрийнх. Холимог ба шинэсэн ойн хэсэг хэсэг төгөл зөвхөн цөөн нутаг нөмөр нөөлөг бүхий бараадана тааралдана. Үетэн ба алаг өвст хээр голлож тааралдах бөгөөд тэдгээр нь уулын ар биеэр тачир ургамалтай уулын хээрийн шинжтэй байдаг. Зүүн хараагаас эхлэн Ерөө хүртэл Хараа голын баруун эрэг дагуухь ихээхэн нутагт жижиг навчит харгана (Caragana microphylla) бүхий жинхэнэ үетэн агьт хээр тааралддаг. Хотос хоолойгоор марцлаг нуга, дэрс үзэгддэг (А.А.Юнатов, 1977 он).

Судалгаа гүйцэтгэсэн талбай нь уулын хээрийн бүсэд хамаарах 2 бүлгэмдлээс бүрдэнэ. Ургамалжлын зүйлийн хувьд 14 овгийн 24 төрлийн нийт 31 зүйл ургамал бүртгэгдсэн. Эдгээр ургамал нь амьдралын хэлбэрийн хувьд мод-2, сөөглөг-2, сөөгөнцөрлөг-3, олон наст өвс-20, хоёр наст-2, нэг наст-2 зүйл ургамал тус тус тэмдэглэгдэв.

Судалгааны талбайн эргэн тойронд ургамал нөмрөг харьцангуй өөрчлөлт багатай. Ургамлын арвийн үнэлгээний хувьд дэд зонхилогч ургамлууд нь cop1, бусад зүйл ургамлууд нь sp-sol үнэлгээтэй байна. Ерөнхий тусгаг бүрхэцийн ихэнх хувийг олон наст өвслөг ургамлууд бүрдүүлж, 2-р ташингыг олон наст ургамлын хагд ба борог өвс бүрдүүлж байна. Ургамлын ташинга үүсгэх байдлаар нь үзвэл сөөглөг ургамал дээд дэд, олон наст өвслөг ургамал дунд дээд, нэг ба хоёр наст ургамлын өнгөрсөн жилийн босоо хагд доод дэд ташингийг бүрдүүлж байна. Ургамлын дундаж өндрийн хувьд олон наст өвслөг ургамал 4.2 см, сөөглөг,

сөөгөнцөрлөг ургамал 5 см. Ургац 94.5-110.4 кг/га.

Амьтны аймаг: Орд газар нь Монгол орны амьтны аймгийн мужлалаар Хэнтийн тойрогт хамаарагдах ба амьтны аймгийн зүйлийн бүрдэл нь ойт хээр, хээрийн амьтдаас бүрдэнэ. 2016 оны зун Бороо голын сав газар, орчны бүсийн ойт хээрт гүйцэтгэсэн хээрийн судалгааны хүрээнд хайрсан далавчтаны багаас Lymantria dispar, Ochlades venata, Glaucopsyche lycormas, Aglais urtica, Minois dryas scopoli, Neptis rivularis, Aporia crataegi, Colias aurorina, Leptidea sinapsis, шулуун далавчтаны багаас Derecantha onos, Gampsoclies sedakovi, Bryodema holdereri, Bryodema tuberculatum, Calliptamus abbreviates, Chorthippus fallax, Chorthippus longicornis, Mongolotettix japonicas, Oedaleus decorus asiaticus, Omocestus haemerroidalis зэрэг зүйлүүд, хос далавчтаны багаас Tachinidae овгийн ялаанууд, хатуу далавчтанаас Epicauta sibirica, Poecilus gebleri, Mylabris speciosa зэрэг зүйлүүд түгээмэл тархсан байна. Төслийн талбайд хоёр нутагтнаас монгол бах, мөлхөгч амьтдаас монгол гүрвэл, бамбай хоншоорт могой, рашааны могой тархсан. Ой, мод бут, голын шугуй, ус намаг, тал хээрийн шувууд амьдрах орчин төслийн талбайд бий. Төслийн талбайгаас Бороо гол уруудаад гол дагуух бургасан шугуй нь өтгөрөх ба мод бутны олон зүйл шувууд зусаж үржих, мөн нүүдлийн үедээ дайран өнгөрдөг. Дулааны улиралд шувуудын зүйлийн бүрдэл нэмэгдэх бол харин хүйтний улиралд цөөвтөр зүйлийн шувуу өвөлждөг. 2016-2017 онд Сайр уулын орд газар орчимд бүртгэгдсэн 53 зүйл шувуудын 28.3% нь суурин, 20% нь нүүдлийн үед дайрч өнгөрдөг бол 26.4% нь зусаж үрждэг шувууд байна. Нүүдлийн шувууд дайран өнгөрөх, мөн зусаж үржих гол орчин нь голын сав газар юм. МАА, Газар тариалан эрхлэх иргэдийн суурьшилт, зам харилцаа зэргээс шалтгаалан том хөхтөний тархалт хязгаарлагдсан ба судалгаа ажиглалтын хугацаанд бор гөрөөс, зэрлэг гахай, монгол тарвага зэрэг том хөхтөн амьтад үзэгдээгүй.

Богино хугацааны ажиглалт судалгааны явцад ажиглагдсан хөхтөн амьтад болон амьдрах орчны нөхцөл, хөхтөний үлий нүх, мөр, ялгадас зэрэг мөр шинж тэмдгийг ашиглан төслийн талбайд 9 зүйлийн хөхтөн байгааг тогтоосон. Цаашдын судалгаагаар хөхтөний зүйлийн тоо нэмэгдэх боломжтой.

Археологийн судалгаа Сэлэнгэ аймгийн Баянгол, Мандал сумдын зааг нутагт орших, ”Демситрейд” ХХК-ий ашигт малтмалын хайгуулын XV-020531 тоот тусгай зөвшөөрлөөр эзэмшдэг “Сайр-Уул” хэмээх 3575.84 гектар талбайд МУИС-ийн ШУС-ийн Антропологи, Археологийн тэнхмээс 2016 оны 10 дугаар сарын 30- наас 10 дугаар сарын 3і-ний хугацаанд Монгол Улсын Соёлын евийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 17.10 заалтыг үндэслэн археологийн хайгуул судалгаа зохион явуулахад түүх, археологийн ямар нэгэн дурсгал

илрээгүй болно. Хэрэв ашигт малтмалын хайгуул, өрөмдлөгийн явцад хүн малын яс, шавар ваар савны хагархай, янз бүрийн хүрэл төмөр эдлэл, түүний хэлтэрхий, хугархай гэх мэт хүний гараар хийж бүтээсэн ямар нэг эд өлөг, шинж тэмдэг илэрсэн тохиолдолд орон нутгийн удирдлага, байгаль орчны хяналтын улсын байцаагч, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэж хамгаалалтанд авах ба Монгол Улсын Соёлын евийн тухай хуулийн холбогдох заалтуудыг биелүүлж МУИС-ийн ШУС- ийн Антропологи, Археологийн тэнхим, ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, Үндэсний музей зэрэг эрх бүхий мэргэжлийн байгууллагад яаралтай хандаж малтлага судалгаа хийлгэхийг зөвлөж байна. Тайланг хавсралтаар үзүүлэв.

***Палеонтологийн судалгаа***

“Демситрейд” ХХК-ны Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших "Сайр-Уул" нэртэй (3575.84 га) хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн хойд хэсгээр дунд- дээд ордовикийн настай Бороогол бүрдлийн интрузив чулуулаг, төв болон өмнөд хэсэгт дунд кембри-доод ордовикийн Хараа группын хурдас, хөндий жалгаар дээд дөрөвдөгч-орчин үеийн сэвсгэр хэмхдэст хурдас тархалттай тул палеонтологийн олдвор эртний амьтан, ургамлын үлдэгдэлгүй юм. Түе тусгай зөвшөөрлийн талбайн төв болон өмнөд хэсэгт 55%

-ийг эзлэн Хараа группын хувирмал тунамал чулуулаг, харин жалга, хөндийнүүдэд дорөвдөгч-орчин үеийн делюв- пролювийн гаралтай хэмхдэст сэвсгэр хурдсууд тархана. Эдгээр метаморф тунамал болон тунамал хурдас чулуулагт өмнөх геологийн судалгааны ажлуудаар палеонтологийн үлдэгдэл илэрч байгаагүй байна. Иймд Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших XV-020531 тоот "Сайр-Уул" нэртэй (3575.84 га) хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд геологи хайгуулын үйл

ажиллагаа явуулахад палеонтологийн талаас харшлах зүйлгүй гэсэн дүгнэлтийг ШУТИС, ГУУИС-ийн Стратиграфи-Палеонтологийн судалгааны төв гарсан байна. Тайланг хавсралтаар үзүүлэв.

***Нийгэм эдийн засаг:*** Сэлэнгэ аймгийн Мандал сум нь 1911-1915 онд Богд хаант Монгол Улсын Түшээт хан аймгийн Баатар бэйлийн хошуу, 1916-1924 онд Баатар вангийн хошуу хэмээх нэртэй байв. Ардын засгийн газрын 1924 оны 68-р тогтоолоор Баатар вангийн хошууны Мандал сум байгуулагджээ. 1961 онд АИХ-ын тэргүүлэгчдийн 1 сарын 9-ны өдрийн 7 дугаар зарлигаар Зүүнхараа хот болгож хотын захиргааг байгуулсан байна. Мандал сум нь өдгөө 9 баг 2 тосгонтой. Нийт 7,3 мянган өрхөд 26,6 мянган хүн ам ажиллаж хөдөлмөрлөн амьдарч байна. Монгол улсын хэмжээнд аймгийн төвөөс алслагдсан сумаас хүн амын тоогоороо 1-рт ордог бөгөөд нэг хавтгай дөрвөлжин км-т 5.3 хүн оногдож байна. Нийт 484,3 мянган га газар нутагтай

төвийн бүсийн аймгуудтай олон улсын төмөр зам, авто замаар холбогдсон дэд бүтэц сайн хөгжсөн сум болон өргөжжээ. Жилд 7800 га талбайд үр тариа, төмс хүнсний ногоо тариалж байна. 2013 оны байдлаар Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 53002,1 сая төгрөг, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл 35935,5 сая төгрөг, Худалдаа үйлчилгээ 11615,6 сая төгрөг, нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 100553,2 сая төгрөгт хүрч 2012 оноос АҮБ үйлдвэрлэлт 56,5%, ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 24,1%, худалдаа үйлчилгээ 8%, нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 36,6%-иар өссөн байна. Мандал сум нь хөдөө аж ахуйн газар 136708 га, ойн сан бүхий газар 309957га, усан сан бүхий газар 2260 га, тусгай хэрэгцээний газар 21384 га, тосгон суурингийн газар 12826 га, дэд бүтцийн газар 1238 га газар нутагтай.

Баянгол сум нь 1931 онд Богдхан уулын аймгийн Баатарвангийн хошууны Хөлий-Баянуул сумын суурин дээр Түнхийн аманд Хараа голын хөндийд байгуулагдан 1954 онд Мандах нэгдэл нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байгаад 1968 онд Баруунхараа САА болон өргөжин 1992 онд шинэ Үндсэн хуулиар Баянгол сум болон цэцэглэн хөгжиж байна. Тус сум нь 197.6 мянган га газар нутагтай, засаг захиргааны анхан шатны нэгж Хараа, Баян, Гонир гэсэн 3 багтай, 5438 хүн амтай, 1590 өрхтэй, төр төсвийн 9 байгууллагатай, 123.4 мянган толгой малтай. Хүн амын тоогоор Сэлэнгэ аймгийн 17 сумаас эхнээсээ 4-д, газар нутгийн хэмжээгээр 10-д ордог хүн амын нягтрал ихтэй 35,9 хүн/га ногддог. Эдийн засгийн бүтэц: Сумын хэмжээнд нийт 100 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж 18.3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж улсад 33,1 сая, аймагт 1458,8 сая, орон нутагт 86,9 сая нийт 1578,8 сая төгрөгийн татвар төвлөрүүлж байна. Тус суманд жилд 10,5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бөгөөд ХАА, газар тариалангийн үйлдвэрлэл тогтмолжиж, уул уурхайн томоохон аж ахуйн нэгж Бороо гоулд ХХК үйл ажиллагаа эрхэлж байгаа нь тус сумын аж үйлдвэрийн бүтцэд томоохон нөлөө үзүүлж байна.

***Хүн ам, дэд бүтэц***: Төвийн бүсэд багтдаг бөгөөд аж үйлдвэрийн салбар, дэд бүтэц сайн хөгжсөн бүс нутагт харъяалагдана. Төслийн талбай нь Улаанбаатар хотоос баруун хойд зүгт 135 км, төмөр замын

Баруун хараа өртөөнөөñ (Баянгол ñум) зүүн тийш 20 км-т орших ба Óлаанбаатар - Сүхбаатарын хатуу ху÷илттай замаañ зүүн хойд зүгт 5 км-т, Зүүн-хараа Бороогийн ордын салдаг үндсэнзамын уулзвараас 1 км-т, Сайр уулын аманд байрлана. Орд нь Хойд-хэнтийн алтны металлогенийн муж дахь Бороо-Зуун модны хүдрийн дүүрэгт, Бороогийн хүдрийн талбайд оршдог. Бороогийн ордын дэд станцаас 7км зайтай, 380V-н цахилгааны шугамд холбогдсон. G-Mobile-н суурин утсан харилцаатай. Хамгийн ойр сум болох Баянголоос (Баруун-хараа) 20

км зайд орших ба ордоос зүүн хойш 2 км-т "Бороо гоулд"-ын алтны үйлдвэр оршино. "Бороо гоулд"-ын алтны үйлдвэр эрчим хүчний төвлөрсөн системд холбогдсон. Мөн үүрэн телефоны аль ч утсаар ярих боломжтой. Дэд бүтцийн хувьд нэн тааламжтай нөхцөлтэй.

## БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛОН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛ НӨЛӨӨЛЛҮҮДИЙН ХУРААНГУЙ

***Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл***: Хөрс хуулах, элс олборлох үед тоос, шороо ихээр үүсгэнэ. Уурхайн малталтууд болон овоолгын дээд талбайгаас салхинд хийсэх тоос, шороо, уурхайд ажиллах машин техникүүдийн шингэн түлшний шаталтаас ялгарах утаа, хөө тортог,
хорт хийнүүд, ажилчидын суурингаас гарах хатуу шингэн хог хаягдлын бохирдол, уурхайлалтын үед гарах тоос, шороо, хөрс хуулах, түрэх, тээвэрлэх, элс угаах зэрэг бүхий л ажиллагаа тасралтгүй явагдах тул бульдозер, экскаватор, автомашин, бусад төхөөрөмжийн дуу чимээ болон хорт хий утаа гарах, тоос шороо дэгдэх зэргээр агаар орчныг бохирдуулж, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлнө.

***Газрын гадарга болон хэвлийд үзүүлэх нөлөөлөл:*** Төслийн зүгээс газрын гадарга болон хэвлийд үзүүлэх гол нөлөөлөл нь барилга угсралтын ажил болон төслийн үйл ажиллагаатай холбоотой уурхайн карьер, овоолго болон тээврийн хөдөлгөөн зэрэг эх үүсвэрүүдээс үүснэ.

***Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл*** : Төслийн хүрээнд төлөвлөж буй ил уурхайн барилга байгууламжид хөрс удаан хугацаанд дарагдана. Туунчлэн дэд бутцийн барилга, байгууламжийн ойр орчимд машин техник, хүний үйл ажиллагаагаар элэгдэл, эвдрэл, бохирдол их үүснэ. Уурхайн уйл ажиллагааны явцад нүүрс-ус буюу шатахуун, түүнтэй төстэй бутээгдэхүүн, мөн химийн бодисын асгаралт, шүүрэлтээс хөрс бохирдох боломжтой. Шатахуун болон химийн бодисын агуулах, сав, машин техникийн тээвэрлэлт ачаалалтын үед асгаралт үүсэж хөрсний боломжит бохирдол ихэнхдээ үүсдэг.

***Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл:*** Хөрс хуулалт болон барилга угсралтын явцад тоосжилт дарахад цэвэр усны нөөц хомсдох, Уулын малталтын үед хөрсний болон гүний усыг зайлуулж усны неөц хомсдох, Барилга угсралтын ажлын явцад барилгын материал хур тунадас болон үерийн усаар угаагдан барилгын материалд агуулагдах бодисууд хөрсөнд нэвчих, улмаар хөрсний бага гүний усыг бохирдуулах, Баяжуулах үйл ажиллагаа явуулахад химийн бодис алдагдахаас үүдэн хөрсний болон гүний усыг бохирдуулах, Уулын ажлын болон ахуйн бохир ус хадгалах савыг соруулах үед асгарч газрын хэвлий болон хөрсийг бохирдуулхаас үүдэн хөрсний усыг бохирдуулах, Уулын ажлын болон ахуйн бохир ус хадгалах сав хүчтэй аадар бороо болон үерийн усаар дүүрч хальхаас үүдэн хөрсөнд нэвчиж хөрсний ус

болон бага гүний усыг борхирдуулах эрсдэлтэй байна.

***Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл:*** Төслийн талбайд ил уурхай байгуулах, шимт хөрсний болон хаягдал чулуулгийн овоолго бий болгох, уурхайн зам, дэд бүтцүүдийн барилгын ажил хийгдэх зэрэгтэй холбоотойгоор хөрс хуулалт явагдах ба эдгээр үйл ажиллагаа нь ургамлан нөмрөгт шууд болон шууд бус нөлөөллийг үзүүлнэ. Мөн уурхайн байнгын үйл ажиллагаа ургамлан нөмрөгт дам нөлөөлөл богино ба урт хугацаанд үзүүлсээр байх юм.

***Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл:*** Барилга угсралтын үед ажиллах хүнд даацын автомашин, техник хэрэгслүүдийн дуу чимээнээс амьтад үргэн дайжих, Ургамлан нөмрөгт төслийн үйл ажиллагааны явцад ялгарсан, асгарсан бохирдуулагч материалууд хуримтлагдсанаас өвсөн тэжээлтэн амьтад хордох, Тоосжилтын улмаас ургамал ургах чадвараа алдан ургамлын арви багассанаас өвсөн тэжээлтнүүд хоол тэжээлийн хомсдолд орох, Төслийн ажилчид санаандгүй болон санаатайгаар амьтадыг устгаж болзошгүй, Шувууд утаанд хордох, цахилгаан хүчдэлд цохиулах зэрэг багтана.

***Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл:*** Төслийг хэрэгжүүлэхд ажиллах хүчийг төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн оршин суугчдаас авч ажиллуулах нь оршин суугчдын амжиргаа, нийгэм эдийн засгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэхээр байна.

## СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУРААНГУЙ

***Агаарын чанар***

- Тоосжилт болон агаар бохирдуулагч хийнүүдийн хэмжилт судалгааг тогтмол хийж, хяналт тавих. Агаарын чанарын MNS 4585:2007 стандарт шаардлагад заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй байх арга хэмжээ авах;
- Хөрс хуулж овоолго хийх ажлыг аль болох цөөн хоногт буюу ТЭЗҮ-д заасан хугацаа болох 168 хоногоос хэтрүүлэхгүй байхаар багтаахаар зохион байгуулах;
- Тоосжилт тархах хүрээ ачиж, тээвэрлэх, буулгах газраас 50-100 м орчимд байхаар зам, овоолгын байршлыг оновчтой сонгох, улмаар байнгын ажлын байрнаас зайдуу байршуулах хэрэгтэй;
- Уурхайн дотоод тээвэрлэлтийн автозамуудыг тоос бага гаргадаг материалаар өнгөлөх, хоногт 2 удаа тогтмол усалж байх, ялангуяа тоосжилт,үндсэн шуурганы гаралт нэмэгддэг хуурайшилттай хаврын улиралд төслийн талбайг усаар норгох, чийглэх, өвөл нь автогрейдрээр тэгшлэх, орсон цасыг замын элстэй хольж, тэгшлэн дагтаршуулах;
- Төслийн талбайн хэмжээнд олон салаа зам гаргахгүй байх, хөрс тээвэрлэсэн автомашиныг хучиж, хөрс, элсний тоос салхинд хийсэж, агаар орчинд тархахаас

урьдчилан сэргийлэх зорилгоор овоолгыг хучих, ургамалжуулах арга хэмжээг авах;

- Уурхайд ашиглах тоног төхөөрөмжийн сонголтыг хийхдээ ялгаруулалтын стандартууд болон түлш зарцуулалтын үр ашгийг нь харгалзан үзэх.
- Техник тоног төхөөрөмжийн үзлэг, шалгалтыг тогмтол явуулж, засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж гүйцэтгэх.
- Тээврийн хэрэгсэлд хорт хийг бууруулах шүүлтүүр суурилуулах.
- Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, тос, маслыг тогтоосон хугацаанд нь сольж байх

***Хөрсөн бүрхэвч***

- Жил бүрийн уулын ажлын төлөвлөгөөнд нөхөн сэргээлтийн ажлын хэмжээг тодотгон, шаардагдах зардлыг тооцож байх
- Нөхөн сэргээгдэж буй газар, түүний хүрээлэн буй орчин нь олборлолтын дараа байгалийн тэнцвэрт байдлаа хадгалсан, унаган төрхөндөө ойртсон, хүн амьтны эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байх нөхцлийг аль болох эртнээс төлөвлөх, уурхайн ашиглалттай зэрэгцүүлэн эхлүүлэх
- Гадаад овоолго хийх талбайг үржил шим багатай, байгалийн нөлөөгөөр эвдэрсэн, гуу жалгатай газрыг сонгон орчны гадаргуутай ландшафтын хэлбэршлийн хувьд нэгдмэл бүтэц бий болгоход анхаарах нь чухал.
- Нөхөн сэргээлтэд хэрэглэх үржил шимт хөрсийг үер бороо, уруйн усанд зөөгдөж урсахааргүй суваг шуудуу жалганы голдирлоос зайдуу газарт хийж түрж овоолго хийх хэрэгтэй
- Хөрсний эмзэг шинж чанарыг харгалзан олборлолтын эхнээс авто замын сүлжээг оновчтой зохион байгуулах, тогтсон маршрутаар цуваа байдлаар мехнизм, техник тоног төхөөрөмж, материалыг тээвэрлэх

***Гадаргын болон газрын доорх ус***

- Голын гулдрил, гүний усны /худаг/ ойролцоо шатахуун цэнэглэхгүй байх, шатах тослох материалын агуулахыг голын гулдрилын нуур тойромоос хамгийн багадаа 100 м зайтай байрлуулах, шатах тослох материал алдагдах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.
- Шүүрлийн усыг хуримтлуулан технологийн усны хэрэглээнд ашиглах, зам усалгаанд ашиглах, Байгаль орчныг хамгаалах, цэвэр усны нөөцийг хэмнэх зорилгоор үйлдвэрийн технологийн усан хангамжинд хэрэглэгдэх усыг хуримтлуулж, тунгаан цэвэршүүлэх

замаар эргүүлэн ашиглах нь зүйтэй.

- Дахин ашиглагдаж буй усыг зөвхөн үйлдвэрлэлд ашиглах төдий биш мөн уурхайн талбай дахь тоосжилтыг дарах, талбайг чийгшүүлэхэд ашиглах, уурхайн шүүрлийн усыг тунгаан цэвэршүүлэн зам услах зэрэг ажилд ашиглах
- Гүний усны мониторингийн цэгүүдэд тогтмол хэмжилт, шинжилгээг хийж улирал бүр тайланг гаргах
- Хөрс хуулалт болон барилга угсралтын явцад тоосжилт дарахад цэвэр усны нөөцийг ашиглахгүй, ахуйн хаягдал усыг цэвэршүүлж чийгшүүлэлтэнд ашиглах
- Ахуйн хаягдал усаар гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулахгүй байх арга хэмжээг авч ажиллах
- Тосгон ба ордыг хаврын шар усны болон хур борооны үерээс хамгаалах арга хэмжээ авч үерийн далан, суваг байгуулах
- Уулын малталтын үед хөрсний болон гүний усыг зайлуулахдаа усан сан байгуулж, хуримтлуулан ашиглах
- Ил уурхайн шүүрлийн усыг уурхайн талбай дахь тоосжилтыг дарах, талбайг чийгшүүлэхэд ашиглах, уурхайн шүүрлийн усыг цэвэршүүлэн зам услах зэрэг ашиглах
- Ахуйн бохирыг зайлуулах байгаль орчин, усны чанарт халгүй орчин үеийн системийг төлөвлөж, хэрэглэх
- Талбайн хэмжээнд байрлах уст цэгүүдэд тогтмол горимын болон чанарын хяналт шинжилгээг явуулах

***Ургамлан нөмрөг***

- Тоосжилт нь ургамлын навчны амсарыг бөглөх, улмаар фотосинтезийн явцыг бууруулах, ургамлын ургалтыг доройтуулах сөрөг нөлөөтэй юм. Иймд хатуу хучилтгүй замд автомашины хурдыг хязгаарлах, замын сүлжээг сайжруулах, тоосжилтыг бууруулах усалгааг хийх
- Уурхайн ногоон байгууламжийн хувьд орон нутгийн байгалийн нөхцлийг харгалзан, тухайн орчны онцлог зохицсон, ган гачиг болон хүйтэнд тэсвэртэй ургамлын төрлийг сонгож тарих
